



## ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 03

Ховд

Цаг үеийн ажлыг эрчимжүүлж, хөдөө аж ахуйн салбарын болон хот, төв суурин газрын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын эрсдэл улам нэмэгдэж, түүний дельта хувилбар Монгол улсад бүртгэгдсэн нөхцөл байдалд ажиллаж, амьдрах онцгой шаардлага гарч байна.

Иймд төрийн бүх шатны байгууллагуудын ажлыг эрчимжүүлж, хөдөө аж ахуйн салбарын болон хот суурин газрын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангаж ажиллах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “л” заалтыг үндэслэн **ДААЛГАХ** нь:

Нэг.Сум, байгууллагуудын дарга, эрхлэгч, эрүүл мэнд, боловсролын салбарын удирдлага, ажилтан албан хаагч нарт:

1.1. Иргэд, албан хаагчдаа Ковид-19 цар тахлын эсрэг вакцинжуулалтанд бүрэн хамруулах талаар онцгой анхаарч, шуурхай зохион байгуулж, 90-ээс доошгүй хувьд хүргэх

1.2. Элсэлтийн ерөнхий шалгалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулах, төгсөгчдийг бүрэн, чанартай хамруулахад анхаарч, бэлтгэл ажлыг сайтар хангах

1.3. 2021-2022 оны хичээлийн жилийг танхимаар зохион байгуулах чиглэлд сургууль, цэцэрлэгийн барилгын болон цахилгаан, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар үйлчилгээ, анги танхимиын тохижилтыг 8 дугаар сарын 25-ны дотор бүрэн хангуулж, хүлээн авах

1.4. Сургууль орчмын аюулгүй байдал, халдварт хамгаалалт, орчны эрүүл ахуйн стандарт хангуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 2021-2022 оны хичээлийн жилийг 9 дүгээр сарын 01-ний өдөр эхлүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангах

1.5. Бороо хур элбэгшиж, гол, нууруудын усны түвшин нэмэгдэж байгаа тул иргэдэд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, болгоомжтой хянуур байх сануулга, сэрэмжлүүлгийг байнга өгч ажиллах

Хоёр. Сум, багийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн салбар байгууллагын дарга, мэргэжилтэн нарт.

2.1. Сумдад бэлтгэвэл зохих өвс тэжээлийн аюулгүйн нөөц, малчдын түвшинд бэлтгэх өвс тэжээл, хужир шүүний хэмжээг хавсралтаар баталсугай.

2.2. 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ханглулах сум, багийн ажлын хэсгийг 2021 оны 08 дугаар сарын 01-ны дотор байгуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, цаг хугацаанд нь хэрэгжилтийг ханглулахад хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг цаг тухай бүр нь авч мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.

2.3. Малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдийг технологит хугацаанд шуурхай зохион байгуулж, нийт малын 30 хувийг 1 хоног тэжээх буюу хавсралтанд заасан хэмжээнд өвс тэжээл, хужир шүүний болон сумын аюулгүйн нөөцийг бүрдүүлэн шаардлагатай цэгүүдэд байршуулах арга хэмжээ авах.

2.4. Сум бүр 8 дугаар сарын 10-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хадлан бэлтгэх төлөвлөгөөг батлан, хадлангийн талбайн зураглалыг гаргаж, хуваарилалтыг зөв зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж, малчдын хороо, нөхөрлөлд түр эзэмшүүлэн, хяналт тавьж хэрэгжүүлэх.

2.5. Хадлан тэжээл бэлтгэх техник тооног төхөөрөмжийн засвар үйлчилгээг 8 дугаар сарын 10-ны дотор дуусгаж, техникийн аюулгүй байдлыг бүрэн ханглулах.

2.6. Өөрийн нутгаас өвс бэлтгэх боломжгүй сумдад хадлангийн нөөц талбай бүхий бусад сумдын удирдлагатай хадлангийн гэрээгээр ашиглах өвс, тэжээл бэлтгүүлж худалдан авах, хужир шүүг өвс тэжээлээр солилцох зэргээр тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

2.7. Өвөл, хаврын бэлчээрийн даацад тулгуурлан сум дундын болон аймаг дундын отрын бүс нутгууд, хилийн зуравс газар, байгалийн тусгай хамгаалалттай газрууд, өөр аймаг, сумын нутагт отроор өвөлжих, хаваржих өрх, малчид, малын тоог 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэх, холбогдох газар, сумдын удирдлагуудтай хийх гэрээ хэлцлийг 9 дүгээр сард багтаан зохион байгуулах.

2.8. Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчин, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, мал эмнэлэгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж шуурхай удирдлагаар ханган ажиллах.

2.9 Малчин өрх бүрийг малын хаашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлшээ бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс,

тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэргээр мал өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулах.

2.10. Нийт хээлтэгч, хээлтүүлэгч малын тохиоог бүрдүүлж, дутагдалтай хээлтүүлэгчийг нөхөн тавих хуц, ухныг 12 дугаар сарын 10-ны дотор багтаан ялгаж, малчдын саналын дагуу суурь зохион байгуулж ажиллах.

2.11. Сум, баг, малчдын харилцаа холбооны найдвартай ажиллагааг хангаж, цаг агаарын гамшигт үзэгдлийн талаарх урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг иргэд, малчдад тогтмол хүргэж байх.

2.12. Намрын ургац хураалтанд шаардагдах хүн хүч, техникийн бүрэн бүтэн байдал, хүрэлцээ хангамж, шатах тослох материалын нөөц бүрдүүлэхэд анхаарч, ургацыг хаягдал багатай хураан авах, хадгалах байр сав бэлтгэх.

2.13. Мал, мах бэлтгэх ажлыг эрчимжүүлэх, тарга хүч муутай малыг бордож борлуулах, мал, мах бэлтгэдэг компани, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжтэй холбоо тогтоон малчидтай холбон, гэрээ байгуулах замаар газар дээр нь борлуулах ажлыг зуучлан зохион байгуулах.

Гурав. Аймгийн Засаг даргын орлогч Т.Жаргалсайхан, мэргэжлийн байгууллагуудын дарга, эрхлэгч, аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад.

3.1. Албан байгууллага, айл өрхүүдийн дулааны шугам сүлжээний урсгал болон их засварын ажлыг 8 дугаар сарын 20-оос 9 дүгээр сарын 15-ны дотор бүрэн хийж дуусган шалгаж, хүлээн авах

3.2 Жилийн хэрэгцээний түлш, нүүрсний 40-өөс доошгүй хувийн татан авалтыг сум, байгууллага, дулааны станц бүрээр бүрэн тооцож 9 дүгээр сарын 25-ны дотор татан авч нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах

3.3. Барилга байгууламжуудын урсгал болон их засварын ажлуудыг 9 дүгээр сарын 1-ний дотор дуусгаж, хаалга цонх, гадна худаг, засвар үйлчилгээг хийлгэн хүлээн авах.

3.4. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга угсралт, их засварын ажилд хяналт хийж, зөвлөн туслах ажлын хэсгийн хуваарийг гаргаж ажиглагч байгууллагуудын дотоод хяналтыг тогтмол хийлгэж чанарт нь онцгой анхаарч ажиллах.

3.5. Сум, байгууллага, айл өрхийн цахилгаан шугам сүлжээний засвар үйлчилгээг 8 дугаар сард багтаан хийх талаар иргэн, аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах

3.6. Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээг 8 дугаар сард багтаан хийх талаар иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах

Дөрөв. Өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангах, дэмжлэг үзүүлж хяналт тавих, мэдээ тайлан ирүүлэх талаар:


4.1. Өр баагдуулж өвөлжилтийн бэлтгэлийг хангах зарим арга хэмжээнд санхүүгийн эх үүсвэр гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

4.2. Хот, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөт ажлын явцын талаар иргэдэд тогтмол мэдээлж, дүнг нээлттэй танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

4.3. Хот суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийн нэгдсэн дүнг 2021 оны 10 дугаар сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

4.4. Хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын хэрэгжилтийн явцын мэдээг 2021 оны 8 дугаар сарын 10-аас эхлэн 10 хоног тутам Хүнс, хөдөө аж ахуйн газарт мэдээлж, нэгдсэн дүнг 10 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ